



Сүхбаатар аймаг дахь Төрийн
аудитын газар

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

СҮХБААТАР АЙМГИЙН 2021 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: СБА-2022/02/НА-СТА-ТЕЗ

Баруун-Урт хот 2022 он



Газрын дарга, тэргүүлэх аудитор М.Нарантуяа
Утас: 70518369 Цахим хаяг: Narantuyam@audit.gov.mn

Аудитын менежер Г.Даваа

Утас: 70512123 Цахим хаяг: Davaag@audit.gov.mn

Аудитор О.Барчидгүнсэн

Утас: 70512127 Цахим хаяг: barchidgunseno@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах
хаягаар авна уу.

АГУУЛГА

Агуулга.....	2
ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР	3
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл.....	4
БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн татварын орлого 133.4 хувиар биелж, татварын бус орлого 11.6 хувиар тасарчээ	5
БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг 1,887.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна.....	7
БҮЛЭГ 3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зарлагыг 45.0 сая төгрөгөөр илүү буюу алдаатай тайлагнасан.	9
БҮЛЭГ 4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгэгдээгүй байна	11
БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 218.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, 6,475.2 сая төгрөгийг зарцуулжээ	11
ДҮГНЭЛТ: 14	
ЗӨВЛӨМЖ:.....	15
Холбогдох байгууллагын санал	15

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны, яам
ЗГ	Засгийн газар
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ОНӨҮГ	Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТТЗ	Төсвийн төвлөрүүлэн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТБОНӨХБАҮХАТ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил
Х	үйлчилгээ худалдан авах тухай хууль
АТБӨЯХАТ	Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
MNS	Монгол улсын стандарт
БЭМС	Боловсрол эрүүл мэндийн сан
ЭМД	Эрүүл мэндийн даатгал
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
ТЕГ	Татварын ерөнхий газар

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудит үндэслэл, эрх	хийх бүрэн	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-т заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторын 2022 оны "Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай" А/12 дугаар тушаалаар батлагдсан Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө, Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг тус тус үндэслэн гүйцэтгэв
Аудитын зорилт		Монгол улсын төсвийн тухай хууль, Сүхбаатар аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайланг шалгаж, дүгнэлт, зөвлөмж гарган аймгийн ИТХ болон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэхэд аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: <ol style="list-style-type: none">1. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн орлогыг бодитой төлөвлөж, төвлөрүүлсэн эсэх2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, зориулалтын дагуу үр дүнтэй зарцуулсан эсэх3. ТЭЗ-ын хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, зорилтот түвшинд нийцсэн эсэх.4. Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт
Аудитын хамарсан хүрээ		Аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан, аймаг, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоол, аймгийн Засаг даргын захирамж, Сангийн яамнаас Сүхбаатар аймгийн 2021 оны аймгийн төсвийн суурь, орлого зарлагыг хянаж ирүүлсэн тооцоо болон бусад материалд тулгуурлан аудитыг гүйцэтгэв.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт		Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 100-400, 4200, Төрийн хяналт, шалгалтын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 "Төрийн аудит. Тулгуур зарчим", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам", арга зүйг баримтлан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа болон судалгаа авах, тайлан баримт материалд тулгуурлан харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэргээр аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа		Аудитыг Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газрын дарга бөгөөд тэргүүлэх аудитор М.Нарантуяа удирдаж, аудитын менежер Г.Даваа чанарын хяналтыг хэрэгжүүлж, аудитор О.Барчидгүнсэн гүйцэтгэв.

БҮЛЭГ 1. Орон нутгийн төсвийн татварын орлого 133.4 хувиар биелж, татварын бус орлого 11.6 хувиар тасарчээ

1.1 Малын тоо толгойд ноогдуулах албан татварыг 3 сум төлөвлөж, батлаагүй, 5 сум 5.2-62.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлжээ

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2021 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1¹, 8.5.2²-т заасан цаглабарын дагуу тухайн шатны ИТХ-д өргөн мэдүүлж, 2020 оны 07 дугаар тогтоолоор баталжээ.

Аймгийн ИТХ-ын 2021 оны 01 дугаар тогтоолоор төсөвт тодотгол хийж, орон нутгийн буюу аймгийн төсвийн татварын орлогыг 7,046.6, татварын бус орлогыг 2,305.3, төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлогыг 50.0, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэгийг 8,917.9, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлгийг 16,679.2, тусгай зориулалтын шилжүүлгийн орлогыг 32,473.3, ЭМД-ийн сангаас санхүүжих 426.3, төсөвт байгууллагын өөрийн орлогыг 85.0, хандив тусламжийн орлогыг 2,000.0, төрийн сангийн оны эхний үлдэгдлээс 959.5 сая нийт 70,943.4 сая төгрөгийн орлого бүрдүүлэхээр баталсан.

ТЕЗ-ийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангаар орон нутгийн нэгдсэн төсвийн татварын орлого 10,561.5, татварын бус орлого 5,083.1, төрийн болон орон нутгийн өмчит бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого 50.0, улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 8,917.9, орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 16,679.2, тусгай зориулалтын шилжүүлгийн орлого 32,473.7, Тусгай сангийн орлого/БЭМС/ 1,263.0, төсөвт байгууллагын өөрийн орлого 118.0, сум хөгжүүлэх сангийн орлого 1,117.9, төсөвт байгууллага болон сум хөгжүүлэх сангийн урьд оны үлдэгдлээс санхүүжих 2,814.3, Төрийн сангийн оны эхний үлдэгдлээс 1,720.6, ЭМД-аас санхүүжих дүнг 426.3 сая төгрөг нийт эх үүсвэр 81,225.5 сая төгрөгөөр төлөвлөсөн. Үүнээс гүйцэтгэл 76,341.3 сая төгрөг буюу 93.9 хувийн хэрэгжилттэй байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн татварын орлогын гүйцэтгэл 14,090.4 сая төгрөг буюу 133.4 хувь, татварын бус орлого 4,495.5 сая төгрөг буюу 88.4 хувийн биелэлттэй байна. Нийт дүнгээр татварын болон татварын бус орлогын гүйцэтгэл 18,585.9 сая төгрөг буюу 118.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №1 Төсвийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл /сая.төг/

Орлогын төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
---------------	------------	-----------	-------	------

¹ аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх

² аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 05-ны дотор батлах

НИЙТ ОРЛОГО	15,644.6	18,585.9	2,941.3	118.8
ТАТВАРЫН ОРЛОГО	10,561.5	14,090.4	3,528.9	133.4
Хүн амын орлогын албан татвар	6,813.5	8,425.8	1,612.3	123.7
Өмчийн татвар	1,720.6	2,292.6	572.0	133.2
Дотоодын бараа ажил үйлчилгээний татвар	440.0	532.0	90.9	120.7
Улсын тэмдэгтийн хураамж	155.7	160.5	4.7	103.0
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	165.3	119.1	-46.2	72.1
Газрын төлбөр	451.8	706.1	254.3	156.3
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	44.5	10.4	-34.1	23.4
Байгалийн нөөц ашигласны төлбөр	565.7	1,755.3	1,189.7	310.3
Бусад татвар	204.4	89.4	-115.0	43.7
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	5,083.1	4,495.5	-587.6	88.4
Хүү, торгуулийн орлого	1,072.5	1,474.2	401.7	137.5
Түрээсийн орлого		13.3	13.3	100
Бусад орлого	4,010.6	3,008.0	-1,002.6	75.0

Татварын болон татварын бус орлогоос 8 төрлийн орлого 4.7-1,189.7 сая төгрөгөөр давж, 4 төрлийн орлого 46.7-1,002.6 сая төгрөгөөр тасарсан. Орон нутгийн төсвийн нэгдсэн орлогын гүйцэтгэлд дараах хүчин зүйлүүд нөлөөлөл үзүүлжээ. Үүнд:

- **Хүн амын орлогын албан татвар:** Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 631 татвар төлөгчөөс 5,242.6, ноос, ноолуур, арьс ширний урамшууллын орлого 146.6, үйл ажиллагааны орлого 25.3, хөрөнгө борлуулсны орлого 30.0, хөрөнгийн орлого буюу иргэдийн хадгаламжийн дансны хүүгийн орлого 808.0, шууд бус орлого 506.0, нийт 6,758.5 сая төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 8,425.8 сая төгрөг төвлөрч биелэлт 123.7 хувьтай байна. Тухайлбал: Цалин хөлс түүнтэй адилтгах орлого 1,122.3 сая төгрөгөөр өссөн нь өмнөх онуудад ногдуулсан татварыг тайлант онд барагдуулсан, ноос ноолуур, арьс ширний үнэ өссөнөөс шалтгаалжээ.
- **Үл хөдлөх хөрөнгийн албан татвар:** Тайлант хугацаанд 658 татвар төлөгчийн 670.0 сая төгрөгийн ногдол үүсгэж, 724.4 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Тухайлбал: сүүлийн жилүүдэд төлөөгүй татварын өр төлбөр төлөгдсөн нь нөлөөлсөн байна.
- **АТӨЯХАТ:** Тайлант онд АТҮТ-д бүртгэлтэй 18,681 тээврийн хэрэгсэлд 440.0 сая төгрөгийн татвар ногдуулж, гүйцэтгэлээр 532.0 сая төгрөг буюу 120.7 хувийн биелэлттэй байна. Аймгийн Татварын хэлтэс 2021 оноос өмнөх тээврийн хэрэгслийн бааз суурийг цэгцэлж, олон жил татвараа төлөөгүй иргэдийн татварыг төлүүлэх ажлыг зохион байгуулсан нь нөлөөлжээ.
- **Хүү торгуулийн орлого:** Тайлант онд ТЕГ-аас ирүүлсэн эрсдэл бүхий 31 татвар төлөгчийг хамруулан Татварын хэлтсээс хяналт, шалгалт хийж, 100.3 сая төгрөгийн алданги, торгууль ногдуулж, түүний 72.4 хувийг барагдуулсан нь орлого давахад нөлөөлсөн байна.
- **Малын тоо толгойд ноогдох албан татвар:** Малын тоо толгойд ноогдох албан татварын хууль батлагдаж, сум бүр татварыг төлөвлөхөөр заасан байна. Тухайн албан татварыг 1,022.4 сая төгрөгөөр ногдуулан баталж, гүйцэтгэлээр 1,540.0 сая төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн. Уг татварын орлогыг 3 сум төлөвлөж, батлаагүй боловч 444.0 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна. Нийт дүнгээр нь авч үзвэл 5 сумын орлого 5.2-62.3 сая

төгрөгөөр дутуу, бусад сумд 4.7-235.7 сая төгрөгөөр давсан гүйцэтгэлтэй байна.

- **Байгалийн нөөц ашигласны төлбөр:** Рашаан ус ашигласны төлбөр: Тайлант онд 13 татвар төлөгчөөс үйлдвэрлэлийн зориулалтаар 493.1 сая төгрөгийн төлбөрийг төвлөрүүлжээ. Баяндэлгэр, Дарьганга, Онгон, Уулбаян, Эрдэнэцагаан сумд ахуйн зориулалтаар 121.1 сая төгрөгийн усны төлбөр ногдуулж, төвлөрүүлсэн байна.
- **Ан амьтны нөөц ашигласны төлбөр:** Тайлант онд БОАЖЯ-аас 10 суманд шонхор шувууны зөвшөөрлийн хураамжийг хуваарилсан ба ангийн зөвшөөрлийн хураамж 1,039.6 сая төгрөгийг сумын төсөвт төвлөрүүлсэн байна.
- **Хог хаягдлын хураамж:** Баруун-Урт, Дарьганга сумдаас бусад сум хог хаягдлын хураамжийг ИТХ-аар батлуулаагүй, зарим сумдын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниас хог хаягдлын хураамжийг хууль журмын дагуу гэрээ байгуулж, сум орон нутгийн төсөвт төвлөрүүлээгүй нь тус орлого 46.2 сая төгрөгөөр тасрахад нөлөөлөл үзүүлжээ.
- **Татварын бус орлого:** Коронавируст халдварын цар тахлын улмаас хөл хорио тогтоож, бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотой хилийн орлого, уул уурхайн компанитай хамтран ажиллах гэрээ байгуулснаас төвлөрөх орлого 1,002.6 сая төгрөгөөр тасарсан байна.

Аудитын илрүүлэлт:

Зарим сумын ИТХ Малын тоо толгойд ноогдуулах албан татварыг баталж, зарцуулах эрхийг олгоогүй, мөн бүрэн төвлөрүүлэх ажлыг оновчтой зохион байгуулаагүй байна. Энэ нь "Малын тоо толгойн албан татвар"-ын тухай хуулийн 5 дугаар зүйл, "Төсвийн тухай хууль"-ийн 60 дугаар зүйлийн 60.2.8, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаал "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын заалттай нийцээгүй байна.

БҮЛЭГ 2. Орон нутгийн төсвийн гүйцэтгэлийг 1,887.5 сая төгрөгөөр илүү тайлагнасан байна

2.1.1 Аймгийн засаг даргын 2021 онд зарцуулах төсвийг 81,225.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 72,555.6 сая төгрөг зарцуулжээ. Батлагдсан төсөв болон гүйцэтгэлийг харьцуулж үзэхэд урсгал зардал 2,422.5, хөрөнгийн зардал 5,142.3, эргэж төлөгдөх цэвэр зээл 1,105.0, нийт 8,669.9 сая төгрөгийн төсөв хэмнэгдсэн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт №2 Орон нутгийн төсвийн нэгдсэн төсвийн гүйцэтгэл /сая.төг/

Нийт зардал	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хэмнэлт Хэтрэлт	Хувь
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	81,225.5	72,555.6	8,669.9	89.3
Урсгал зардал	59,110.4	56,687.9	2,422.5	95.9
Бараа,ажил үйлчилгээний зардал	57,316.3	55,040.6	2,275.7	96.0
Цалин хөлс нэмэгдэл урамшил	33,745.5	33,039.7	705.7	97.9
АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,440.3	4,298.1	142.2	96.8

Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,464.3	5,223.9	240.4	95.6
Хангамж, бараа материалын зардал	1,275.9	1,220.1	55.8	95.6
Нормативт зардал	1,554.7	1,485.1	69.6	95.5
Эд хогшил урсгал засварын зардал	1,394.4	1,261.0	133.5	90.4
Томилолт, зочны зардал	153.8	121.5	32.3	79.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	3,347.5	3,147.4	200.1	94.0
Бараа үйлчилгээний бусад зардал	5,939.9	5,243.8	696.1	88.3
Татаас	257.2	245.2	12.0	95.3
Урсгал шилжүүлэг	1,536.9	1,402.0	134.8	91.2
Хөрөнгийн зардал	20,155.5	15,013.2	5,142.3	74.5
Эргэж төлөгдөх зээл	1,959.6	854.6	1,105.0	43.6

Цалин хөлс нэмэгдэл урамшил, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материалын зардал, норматив зардал, эд хогшил урсгал засварын зардал, томилолт зочны зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардал, татаас, урсгал шилжүүлэгт нийт 59,110.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 56,687.9 сая төгрөг зарцуулж 93 хувийн хэрэгжилттэй, хөрөнгийн зардалд 20,155.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 15,013.2 сая төгрөг буюу 74.5 хувийн биелэлттэй, эргэн төлөгдөх зээл 1,959.6 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 854.5 сая төгрөг буюу 43.6 хувийн биелэлттэй байна.

Орон нутгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн хэмнэлт, хэтрэлтийн шалтгааныг авч үзвэл: Орон нутгийн татварын бус орлого 587.6 сая төгрөгөөр тасарсан, орлогын болон тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүгийн дэмжлэг дутуу санхүүжсэн нь нөлөөлжээ. Үүнд:

- ЭМД-ын сангаас санхүүжих үндсэн тусламж үйлчилгээг үзүүлээгүйгээс 171.3 сая төгрөгөөр тасарсан. Энэ нь ковид-19 цар тахлаар өвдсөн иргэд хэвтэн эмчлүүлснээс шалтгаалжээ.
- Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл буюу сум хөгжүүлэх сангийн зээл, зээлийн хүүгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд төлж барагдуулаагүй, ковид-19 цар тахлын улмаас СХС-ийн зээлийг санхүүжүүлээгүй зэргээс шалтгаалан 1,105.0 сая төгрөг хэмнэгдсэн харагдахад нөлөөлж байна. Мөн 1,013.6 сая төгрөгийн үлдэгдлийг улс, орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн нь тус тус нөлөөлжээ.

Аудитын илрүүлэлт:

ЭМД-ын сангаас Ковид-19 цар тахлаар өвдсөн иргэдийг эмчлэх санхүүжилтийг байгууллагын нэмэлт дансаар дамжуулан зарцуулсны үлдэгдэл 55.2 сая, үндсэн үйл ажиллагаатай холбоотой хөтөлбөр, арга хэмжээний зардлын үлдэгдэл 33.5 сая нийт 88.7 сая төгрөгийг Төсвийн тухай хуульд заасны дагуу төвлөрүүлээгүй үлдэгдлээр тайлагнажээ.

Төсвийн гүйцэтгэлээр төсөвт байгууллагууд эд хогшил худалдан авах зарлагын ангилалд батлагдаагүй, ОНӨГ-аас хөрөнгө худалдан авах зөвшөөрөл аваагүй 943.8 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн.

Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн зарим газрууд олсон орлогоороо өөрийгөө санхүүжүүлж чадахгүй, төсвөөс санхүүгийн дэмжлэг авч, төсвийн гүйцэтгэлд зарлага бий болгосон байна. Тухайлбал: Бичигт их өргөө, Сүхбаатар хөгжил, үйлдвэр технологийн парк ОНӨААТҮГ-т 110.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг олгосон байна.

Мөн орон нутгийн өмчит аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар шинээр үүсгэн байгуулж, 77.5 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлж, төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг жишиг бий болж байна. Тухайлбал: Бичигт хөгжил ОНӨААТҮГ, Амгалан дэнж ОНӨААТҮГ

Сумдын ИТХ-аас засаг даргын мөрийн хөтөлбөр хэрэгжүүлэх зардалд 586.2 сая төгрөгийг нэр төрөл, хөтөлбөр, арга хэмжээ тус бүрээр батлуулаагүй нь төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна. Тухайлбал: Дарьганга 53.0, Наран сум 18.5, Онгон 44.0, Түмэнцогт 106.7, Уулбаян 50.0, Халзан 30.0, Баруун-Урт сум 284.0 сая төгрөгийг тус тус баталж, гүйцэтгэлээр 497.1 сая төгрөг зарцуулжээ

Төсвийн хэмнэлтэд тооцогдохгүй төсвийн үлдэгдэл 24.7 сая төгрөгийг харилцагч байгууллага руу илүү шилжүүлж авлагаар бүртгэсэн, 19.1 сая төгрөгийн бараа материал нөөцөлсөн ба нийт 43.8 сая төгрөгийг төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлээгүй байна.

Төсвийн хэмнэлтэд тооцогдох 17.2 сая төгрөгийг төсвийн эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй, 20.3 сая төгрөгийг зориулалт бус зарцуулсан ба нийт 37.5 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан.

Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай"-ийг мөрдөөгүй, төсвийн хэмнэлтийн горимыг зөрчсөн 310.7 сая төгрөгийн зарцуулалт хийгдэж, төсвийн сахилга бат, хариуцлага зөрчигдсөн байна.

Эдгээр алдаа зөрчил нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4, 6.4.8, 7 дугаар зүйлийн 7.7, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 45 дугаар зүйлийн 45.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, Сангийн сайдын 2021 оны 190 дугаар тушаалтай тус тус нийцэхгүй байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв илэрхийлээгүй 981.3 сая, төсвийн зарлагыг 44.0 сая төгрөгөөр илүү буюу алдаатай тайлагнасан байна.

БҮЛЭГ 3. Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зарлагыг 45.0 сая төгрөгөөр илүү буюу алдаатай тайлагнасан байна.

3.1 Орон нутгийн нэгдсэн төсөвт хөрөнгийн зардалд 20,155.1 сая төгрөг төсөвлөснөөс гүйцэтгэлээр 15,013.2 сая төгрөг буюу 74.4 хувийн хэрэгжилттэй байна.

Тухайн жилд авто замын санг 530.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс 5 төсөл, арга хэмжээнд санхүүжилт олгож, гүйцэтгэл 427.0 сая төгрөг буюу 80.6 хувийн биелэлттэй байна. Үүнээс 231.8 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээ 100 хувь хэрэгжиж, 1 төсөл арга хэмжээ 195.2 сая төгрөг буюу 78.6 хувийн биелэлттэй байна.

Харин "Баруун-Урт сумын 7-р багт Эко хороолол"-ын замын сайжруулалтын ажлын тендер шалгаруулалтыг 2 удаа зарлаж, аж ахуй нэгж байгууллага оролцоогүйгээс 50.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр өмнөх оноос шилжиж ирсэн 7 төсөл, арга хэмжээг 542.9, шинээр хэрэгжиж буй 58 төсөл арга хэмжээг 10,040.2, нийт 65 төсөл



хэмжээг 10,583.1 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 7,786.7 сая төгрөг буюу 73.5 хувийн хэрэгжилттэй байна. Дээрх төсөл арга хэмжээнээс 4,871.3 сая төгрөгийн 40 төсөл арга хэмжээг 100 хувь гүйцэтгэсэн, 2,915.4 сая төгрөгийн 16 төсөл арга хэмжээ дутуу, барьцаа санхүүжилт 719.7 сая төгрөг мөнгөн хөрөнгийн дансанд үлдэгдлээр байна. Төлөвлөсөн дүнтэй харьцуулахад 2,076.7

сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй.

ОНӨГ-ын хөрөнгө худалдан авах 9.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд төлөвлөж, гүйцэтгэлийг тайлагнажээ.

Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр шинээр хэрэгжиж буй 199 төсөл арга хэмжээг 9,033.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 150 төсөл арга хэмжээ 6,025.3 сая төгрөг буюу 66.7 хувийн хэрэгжилттэй байна. Дээрх төсөл арга хэмжээнээс 3,620.8 сая төгрөгийн 137 төсөл арга хэмжээг 100 хувь гүйцэтгэсэн, бүрэн хэрэгжсэн боловч 602.9 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээний санхүүжилт дутуу буюу хийгдээгүй, дараа онд санхүүжигдэхээр шилжсэн, 1,801.6 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ дутуу, 2,169.2 сая төгрөгийн 49 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Улсын төсвөөс авах санхүүжилт дутуу хийгдсэн, ковид-19 цар тахлын өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан хөрөнгө

оруулалтын ажлууд удааширсан, хил гааль хаагдсан, тендер зарласан боловч аж ахуйн нэгж байгууллага оролцоогүй зэргээс шалтгаалан Сүхбаатар 1,043.0 сая төгрөгийн 10 төсөл арга хэмжээ, Түмэнцогт 469.0 сая төгрөгийн 8 төсөл арга хэмжээ, Мөнххаан 145.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ, Эрдэнэцагаан 167.4 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ, бусад сумын 344.6 сая төгрөгийн 17 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

Аудитын илрүүлэлт:

Төсвийн гүйцэтгэлд Асгат сумын Сум хөгжүүлэх сангийн 45.0 сая төгрөгийг хөрөнгийн зардалд илүү илэрхийлж, алдаатай тайлагнасан байна.

Иргэдийн саналаар дэмжигдээгүй 273.4 сая төгрөгийн 18 төсөл, арга хэмжээг санхүүжүүлж, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалтай нийцээгүй зарцуулалт хийгдсэн.

ОНХС-ийн аймагт 2,076.7 сая төгрөгийн 9 төсөл арга хэмжээ, сумдад 2,169.2 сая төгрөгийн 49 төсөл арга хэмжээ, авто замын сангийн 50.0 сая төгрөгийн 2 төсөл арга хэмжээ хэрэгжээгүй байна.

БҮЛЭГ 4. Төсвийн гүйцэтгэлийн тайлан хөтөлбөр арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, танилцуулгын хамт бэлтгэгдээгүй байна

Сүхбаатар аймгийн Засаг даргын 2021 оны төсвийг 17 хөтөлбөр, 138 төсвийн захирагчийн хүрээнд 81,225.5 сая төгрөг зарцуулахаар ИТХ-аас зориулалт, эдийн засгийн ангиллаар баталсан байна.

Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэж батлуулаагүй, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнаагүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаал "Санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам", 2012оны 244 дүгээр тушаал "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам батлах тухай"-тай тус тус нийцээгүй байна.

БҮЛЭГ 5. Нэмэлт төсвийн гүйцэтгэлээр 218.2 сая төгрөгийг буцаан төвлөрүүлж, 6,475.2 сая төгрөгийг зарцуулжээ

Сүхбаатар аймгийн ТЕЗ-ийн 2021 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлээр ЗДНХ, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,992.8, хандив тусламж 197.9, дээд шатны төсвийн захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 1,784.2, төсвийн

байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 2,773.8 сая нийт 6,748.7 сая төгрөг төвлөрч, гүйцэтгэлээр 6,475.2 сая төгрөгийг зарцуулж, 218.2 сая төгрөгийг төсвийн дансанд төвлөрүүлж, нийт 6,693.4 сая төгрөгийг зарцуулж, Эрүүл мэндийн төвүүдийн харилцах дансанд 55.2 сая төгрөг үлдэгдэлтэй байна.

Хүснэгт №3 орон нутгийн нэгдсэн төсвийн нэмэлт төсвийн гүйцэтгэл (сая.төг)

Нийт зардал	Гүйцэтгэл
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	6,693.4
Урсгал зардал	6,693.4
Бараа,ажил үйлчилгээний зардал	5,907.9
Цалин хөлс нэмэгдэл урамшил	685.2
АО-с нийгмийн даатгалд төлөх шимтгэл	79.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	77.1
Хангамж, бараа материалын зардал	291.2
Нормативт зардал	1,007.9
Эд хогшил урсгал засварын зардал	436.8
Томилолт, зочны зардал	5.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	1,574.8
Бараа үйлчилгээний бусад зардал	1,749.8
Урсгал шилжүүлэг	785.5

Дээрх зардлыг дараах эх үүсвэрээс санхүүжүүлжээ. Тухайлбал: Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн даатгалын сангаас Ковид-19 цар тахлын санхүүжилт, Засгийн газраас усны үнийн чөлөөлөлт, БШУЯ, СЯ-аас орон нутагт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрийн санхүүжилт, Статистикийн хэлтсээс оготно устгал, мал тооллогын санхүүжилт, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, төсвийн байгууллага өөрийн өмчийг түрээсэлсний орлого, хөрөнгө акталж худалдан борлуулсны орлого, туслах аж ахуйн орлого төвлөрсөн байна.

---oOo---

Холбогдох байгууллагын санал:

СҮХБААТАР АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ХЭЛТЭС

20000 Баянзүрх дүүрэг, Сүхбаатар сум

2022.05.04 6/467

Танхим /Хүндэтгэл/ № 1

СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Хариу хүргүүлэх тухай

"Орон нутгийн төсвийн Ерөнхийлөн захирагчийн 2021 оны төсвийн гүйцэтгэл"-д хийсэн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах тайлбарыг хүргүүлж байна.

Зөвлөмж-1. Сумдын ИТХ-аар малын тоо толгойд ноогдуулах албан татварыг баталж зарцуулах, мөн бүрэн ажлыг оновчтой зохион байгуулах ажлыг хангуулах

-Малын тоо толгойн албан татварын тухай хууль нь 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс хэрэгжиж эхэлсэн шинэ хууль, мөн Короновируст халдвар (Ковид-19) цар тахлын үед иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор 2021 оны 01 дүгээр сард Засгийн газрын хуралдаанаар тухайн татварыг 2021 оны 07 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл авахгүй байх чиглэлийг аймаг сумын ИТХ, ЗДТГ-т хүргүүлсэн зэргээс шалтгаалж энэ төрлийн орлогын бүрдүүлэлт хангалтгүй байсан. 2022 оны хэлтсийн ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу энэ чиглэлээр аймаг, сумдын ИТХ, Татварын хэлтэстэй хамтран ажиллана.

Зөвлөмж-2. Тухайн жилийн төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг төсвийн захирагч бүрээр бэлтгэн ИТХ-аар батлуулж, чанарын болон тоон хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэлийг аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Төрийн аудитын байгууллагад тайлагнах

Сангийн сайдын 2021 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн "Загвар маягт шинэчлэн батлах тухай" 204 дүгээр тушаалаар аймаг, сумын тогтоолын маягтыг баталсан байдаг бөгөөд тогтоолын 1 дүгээр хавсралтаар "Аймаг/нийслэлийн төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоон хэмжээний үзүүлэлт"-ийг батлахаар заасан байдаг. Энэ дагуу 2021 оны 11 дүгээр сард төсвийн ерөнхийлөн захирагч нараас тухайн хавсралтын дагуу тоон болон чанарын үзүүлэлтийг ирүүлэхийг шаардаж авсан боловч ирүүлсэн мэдээлэл нь шаардлага хангахгүй, зарим нэг нь илт бодит бус мэдээлэл байсан ба тухайн үзүүлэлтийг үнэн зөв эсэх, шаардлага хангаж байгаа талаар төсвийн мэргэжилтэн цаашлаад аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэс дангаар шийдвэрлэх боломжгүй байсан тул Аймгийн ИТХ-д хэлэлцүүлэхээр оруулаагүй болно. Мөн төсвийн шууд захирагч, төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн төслийн саналыг Сангийн яамнаас ирүүлсэн удирдамжийн дагуу маягтаар 07 дугаар сард авдаг бөгөөд удирдамжид дээрх хавсралтын маягт байхгүй, тухайн маягтын дагуу төсөв, гүйцэтгэлийг хэн хэзээ хаана гаргаж өгөх нь журамлагдаагүй байдаг. Энэ

мэдээллийг холбогдох байгууллагуудаас дахин шаардан авч боловсруулж байгаа бөгөөд 5 дугаар сард болох аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэхээр төлөвлөж байна.

САНХҮҮ, ТӨРИЙН САНГИЙН
ХЭЛТСИЙН ДАРГА



ДАРИУНЖАРГАЛ

Ирүүлсэн саналд өгсөн тайлбар:

Сүхбаатар аймгийн ЗДТГ-ын санхүү, төрийн сангийн хэлтсийн 2022 оны 5 дүгээр сарын 04-ны өдрийн 6/407 дугаар албан бичгээр 2 тайлбар ирүүлсэн. Ирүүлсэн тайлбарыг аудитын баг судалж үзээд тайлангийн төсөлд өөрчлөлт оруулах шаардлагагүй гэж үзсэн.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

Орон нутгийн төсвийн нэгдсэн орлогыг 81,225.5 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 76,341.3 сая төгрөг буюу 93.9 хувийн биелэлттэй байна

Малын тоо толгойд ноогдуулах албан татварыг 3 сум төлөвлөж, батлаагүй, 5 сум 5.2-62.3 сая төгрөгийг дутуу төвлөрүүлжээ

Төсвийн гүйцэтгэлийн тайланд хөрөнгийн зарлагыг 45.0 сая төгрөгөөр илүү буюу алдаатай тайлагнасан

Төсвийн гүйцэтгэлийн тайланг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв илэрхийлээгүй 981.3 сая, төсвийн зарлагыг 906.2 сая төгрөгөөр илүү буюу алдаатай тайлагнасан байна

Төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт, төсвийн захирагч бүрээр бэлтгэж, батлуулаагүй, гүйцэтгэлийг Төсвийн тухай хуульд нийцүүлэн тайлагнаагүй байна

Орон нутгийн нэгдсэн төсвийн урсгал зардалд 59,110.4 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 56,687.9 сая төгрөг зарцуулж 93 хувийн хэрэгжилттэй, хөрөнгийн зардалд 20,155.5 сая төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 15,013.2 сая төгрөг буюу 74.5 хувийн биелэлттэй, эргэн төлөгдөх зээл 1,959.6 сая төгрөг батлагдсанаас гүйцэтгэлээр 854.5 сая төгрөг буюу 43.6 хувийн биелэлттэй байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитаар өгсөн дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг өгч байна.

Сүхбаатар аймгийн Засаг дарга, Санхүү төрийн сангийн хэлтэс:


1. Сумдын ИТХ-аар малын тоо толгойд ноогдуулах албан татварыг баталж, зарцуулах, мөн бүрэн төвлөрүүлэх ажлыг оновчтой зохион байгуулах ажлыг хангуулах
2. Төсвийн орлогыг орлогын нэр төрлөөр жигд биелүүлж, тасарсан орлогуудад судалгаа, дүгнэлт хийж орлогыг бодитой төлөвлөн, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах
3. Тухайн жилийн төсвийг хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүн, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг, төсвийн захирагч бүрээр бэлтгэн ИТХ-аар батлуулж, чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн гүйцэтгэлийг аймгийн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт Төрийн аудитын байгууллагад тайлагнах
4. Монгол улсын 2022 оны төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 2021 оны 388-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллах
5. Төсвийн гүйцэтгэлийн тайланг эдийн засгийн ангиллын дагуу үнэн зөв илэрхийлээгүй, төсвийн зарлагыг илүү буюу алдаатай тайлагнах зөрчлийг бууруулах чиглэлээр санхүүгийн ажилтнуудад нэгдсэн сургалт зохион байгуулж, ур чадварыг дээшлүүлэх

Зөвлөмжийн биелэлтийг 2022 оны 11 дугаар сарын 01-ний дотор багтаан Сүхбаатар аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

ТАЙЛАН БИЧСЭН:

АУДИТОР  О.БАРЧИДГҮНСЭН

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
 НАРАНТУЯА
АУДИТЫН МЕНЕЖЕР
Г.ДАВАА

2217344021
ЛН-А0042 9054561



СҮХБААТАР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 05 сарын 04 өдөр

Дугаар А/08

Баруун-Урт сум

Аудитын тайланг баталгаажуулах
тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1 дахь заалт, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/207 тоот тушаалын 1.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сүхбаатар аймгийн 2021 оны Төсвийн гүйцэтгэлийн тайланд баталгаажуулах аудит хийж, дүгнэлт гаргасан санхүүгийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Тус аудитаар илрүүлсэн зөрчлийг арилгуулах албан шаардлага, зөвлөмжийг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланд тусгасан зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар авсан арга хэмжээ, түүний үр дүнг 2022 оны 8 дугаар сарын 30-ны дотор ирүүлэхийг аймгийн Засаг дарга /М.Идэрбат/-д даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *М.Нарантуяа* М.НАРАНТУЯА

